



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 1157

Хараат

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “МӨНХБАЯЛАГ РЕСУРС” ХХК-ны гүйцэтгэсэн “Иргэний танхимын тоног төхөөрөмж” – ийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Бямбасүрэн (ИХТ-ын нарийн бичгийн дарга)

Нарийн бичиг: Х.Оюунбилэг (Татварын байцаагч)

Гишүүд: М.Доржсүрэн (Нярав)

2. Гүйцэтгэлийн чанар үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч хүлээн авсан акт үйлдэж баталгаажуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Ажил хүлээлцсэн акт холбогдох бичиг баримтыг үндэслэн ЗДТГ-ын иргэний танхимын өмчид бүртгэхийг нягтлан бодогч (Ж.Чулуунтогтох) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



4823000097